

БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Бэлтгэсэн: “Биржийн бус зах зээлийн бүртгэлийн нэгж”



MONGOLIAN ASSOCIATION OF SECURITIES DEALERS

☎ (+976) 7013-3339

@ info@masd.mn

📍 Chingeltei Dist, 1st Khoroo, Peace Ave, Express tower 11-01

MINING WEEK & MINEPRO 2024 АРГА ХЭМЖЭЭНД БҮРТГЭЛИЙН НЭГЖ ОРОЛЦОЖ ТАНИЛЦУУЛГА ХИЙЛЭЭ.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциациас 2024 оны 10 дугаар сарын 02-05-ны өдрүүдэд зохион байгуулсан "Mining Week & MinePro 2024" олон улсын уул уурхайн үзэсгэлэн, чуулга уулзалтад Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо болон Биржийн бус зах зээлийн бүртгэлийн нэгж оролцлоо. Тус арга хэмжээний үеэр Биржийн бус зах зээлээс хэрхэн богино хугацаанд санхүүжилт татах боломжийг танилцуулсан юм. Мөн Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооны Гадаад харилцаа, хамтын ажиллагааны захирал Э.Мөнх-Өргөө СММ танхимд "Биржийн бус зах зээл" сэдвээр илтгэл тавьж, гадаад, дотоодын олон мэргэжилтнүүдэд үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүргэлээ.



ОТС.MN ПЛАТФОРМЫН ШИНЭЧЛЭЛТИЙГ СИСТЕМ ХӨГЖҮҮЛЭЛТИЙН БАГТАЙ ХАМТРАН ХИЙЛЭЭ.

2024 оны II дугаар улиралд www.ots.mn платформын хөгжүүлэлт, шинэчлэлтийн хүрээнд шууд оролцогч байгууллагуудаас Google Form ашиглан санал, хүсэлтийг авсан. Уг санал асуулгаар ирүүлсэн шууд оролцогчдын саналуудыг нэгтгэн, платформын хөгжүүлэлтийн багт хүргүүлж, хэрэгжүүлэх боломжтой өөрчлөлт, сайжруулалтуудыг амжилттай хийж гүйцэтгэлээ. Энэхүү өөрчлөлтийн хүрээнд хийгдсэн онцлох шинэчлэлтүүдийг дурдвал:

- **Үнэт цаасны самбарын ангилал:** Үнэт цаасыг самбарын дагуу ангилж харах боломжийг нэвтрүүлсэн.
- **Андеррайтерийн тайлан:** Андеррайтерийн тайланг транч тус бүрээр оруулах шаардлагагүй буюу нэг дор оруулах боломжтой болсон.
- **Delist үнэт цаас:** Арилжаанаас хасагдсан (Delist) үнэт цаасыг хянах, харах боломжтой болсон.
- **Хоёрдогч зах зээлийн хяналт:** Хоёрдогч зах зээлд арилжаалагдах боломжтой болон боломжгүй үнэт цаасыг ялган харах боломжтой болсон.

Эдгээр өөрчлөлт нь хөрөнгө оруулагчид, брокерууд болон зохицуулагч байгууллагуудад үнэт цаасны төлөв байдлыг илүү ойлгомжтой болгох, хянах боломжийг бүрдүүлж, арилжааны шийдвэр гаргахад чухал дэмжлэг үзүүлэх юм.



БАНК САНХҮҮГИЙН АКАДЕМИЙН ХАМТРАГЧ БАЙГУУЛЛАГА HOUSE OF TRAINING-ААС ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТАД БҮРТГЭЛИЙН НЭГЖ ХАМРАГДЛАА.

Монголын хөрөнгийн зах зээлийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах хөтөлбөрийн хүрээнд 2024 оны 11 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд Банк Санхүүгийн Академи, Люксембургийн "House of Training" олон улсын сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулсан "Responsible Investing: Context, Challenges, and Best Practices in Asset Management" сургалтад Биржийн Бус Зах Зээлийн (ББЗЗ) бүртгэлийн нэгжийн ажилтнууд амжилттай хамрагдлаа. Энэхүү сургалт нь хөрөнгө оруулалтын менежментийн нөхцөл байдал, тулгарч буй бэрхшээлүүд, түүний үүрэг, Тогтвортой санхүүгийн шилдэг туршлага, хөрөнгө оруулалтын менежментийн ESG-ийг хэрхэн нэгтгэх, хөрөнгө оруулалтын менежментийн өсөлтийн стратеги, эрсдэлийн менежмент, инновац, технологийн интеграци хийх боломжууд сэдвээр мэдлэг ойлголтыг өгсөн ач холбогдолтой үйл явдал боллоо.

ШУТИС-БУХС-Н ЗОХИОН БАЙГУУЛСАН "БИД ИРЭЭДҮЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД 2024" ТЭМЦЭЭНД ХАМТРАН АЖИЛЛАА.

2024 оны 12 дугаар сарын 07-ны өдөр ШУТИС-Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль (БУХС)-ийн жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Бид ирээдүйн хөрөнгө оруулагчид 2024" тэмцээн амжилттай болж өндөрлөлөө. Энэ жилийн тэмцээнд Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо (МУЦАЭХ) хамтрагч байгууллагаар оролцлоо. Тус тэмцээний Тэргүүн байрыг эзэлсэн багт өргөмжлөл, үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрх олгох сургалтад хамрагдах эрхийн бичиг гардууллаа.

БЛОКЧЭЙН ТЕХНОЛОГИЙГ ЗАХ ЗЭЭЛД БҮРЭН ШИЛЖИХ ХҮСЭЛТИЙГ СЗХ-НЫ СЭНДБОКСЫН АЛБАНД ХҮРГҮҮЛЛЭЭ.

Холбоо нь Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 491 тоот тушаалын дагуу "Сэндбокс зохицуулалтын орчин"-д орох зөвшөөрөл авсан. Энэхүү зөвшөөрлийн хүрээнд блокчэйн арилжааны системийг 1 жилийн хугацаанд амжилттай туршиж, технологийн хувьд бэлэн болсон гэж үзэж, үндсэн зах зээлд бүрэн нэвтрүүлэх хүсэлт болон үр дүнгийн тайланг 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Сэндбоксын албанд хүргүүлээ.

СЭЗИС-Н ОЮУТНУУДАД ТАНИЛЦУУЛГА ХИЧЭЭЛ ОРЛОО.

2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Биржийн Бус Зах Зээлийн (ББЗЗ) бүртгэлийн нэгжээс Санхүү, Эдийн Засгийн Их Сургууль (СЭЗИС)-ийн оюутнуудад "Үнэт цаасны зах зээлийн эрх зүй" хичээлийн хүрээнд танилцуулга хийлээ.

Тус танилцуулга нь биржийн бус зах зээлийн талаар ерөнхий ойлголт өгөхөөс гадна, хууль эрх зүйн зохицуулалт, үндсэн чиг үүрэг, мөн зах зээлийн статистик тоон мэдээлэл зэрэг олон талт сэдвийг хамарсан болно.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ АЖЛЫН АЛБАНААС ББСБ-УУДЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТИЙГ АВЧ АЖИЛЛАЖ БАЙНА.

СЗХ-ны "Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх, түүнд хяналт тавих журам"-ыг хүчингүй болсонтой холбоотойгоор СЗХ-ны 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 3/2873 тоот албан бичгийн дагуу өрийн хэрэгсэл гаргахаар хүсэлт ирүүлсэн ББСБ-уудыг СЗХ-с тогтоосон зохистой харьцаа үзүүлэлтийг хангаж байгаа эсэх талаар дүгнэлт авч эхэлсэн. Тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албанаас 26 ББСБ дээр уг дүгнэлтийг гаргуулсан байна.

ЭРГЭН ТӨЛӨЛТ БҮРЭН ХИЙГДСЭН ӨРИЙН ХЭРЭГСЛҮҮДИЙГ БҮРТГЭЛЭЭС ХАСЛАА.

2024 оны IV дүгээр улиралд хугацаа нь дуусаж эргэн төлөлтөө хийсэн өрийн хэрэгслүүд эргэн төлөлтийн тайлангаа баталгаажуулан, www.otc.mn платформд оруулсан. Уг тайлангуудад хяналт хийж, ҮЦТХТ-тэй эргэн төлөлт хугацаандаа бүрэн хийгдсэн эсэхийг тооцоо нийлж, бүртгэлээс хасаж шийдвэрлэлээ. Тайлант хугацаанд 357,662,000,000 төгрөгийн эргэн төлөлт хийгдсэн байна. Ингэснээр нийт 1,060,489,776,326 төгрөгийн эргэн төлөлт амжилттай хийгдлээ.

БҮРТГЭЛИЙН ХОРООНЫ ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ

2024 оны IV дүгээр улиралд Бүртгэлийн хороо 36 удаа хуралдан нийт 55 тогтоол гаргаснаас энгийн бүртгэсэн 27, нөхцөлтэй бүртгэсэн 22, бүртгэлээс хассан 4, шууд оролцогчоор бүртгэх тухай 1, үнэт цаас бүртгэхээс татгалзах тухай 1 тогтоол тус тус батлагдсан байна. Бүртгэлийн хорооноос тусгай нөхцөл тавьж бүртгэсэн 22 тогтоолоос нөхцөл хэрэгжсэн 11, хүлээгдэж байгаа 4, нөхцөл нь тухайн бонд бүртгэлтэй байх хугацаанд үргэлжлэх 7 тогтоол байна. Тайлант хугацаанд огт биелэгдээгүй тогтоол байхгүй бөгөөд андеррайтерийн зүгээс ирүүлсэн материалыг тухай бүр Бүртгэлийн хорооны гишүүдэд мэдээлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн үнэт цаасны үүргийн гүйцэтгэл хангуулах арга болох барьцааны зүйлийг улсын бүртгэлд бүртгүүлэхийг шаардан, бүртгүүлсэн улсын дугаарыг тэмдэглэн бүртгэн ажиллаж байна.



БҮРТГЭЛИЙН ХОРООНЫ 2024 ОНЫ 10 САРЫН 16-НЫ ӨДРИЙН БХ 24/126 ТООТ ТОГТООЛООР "ЭС ЖИ КАПИТАЛ ҮЦК" ХХК ШУУД ОРОЛЦОГЧООР БҮРТГЭГДЛЭЭ.

БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ШУУД ОРОЛЦОГЧИД:

2024 оны IV дүгээр улирлын байдлаар Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоонд бүртгэлтэй биржийн бус зах зээлийн арилжаанд оролцох эрхтэй бүртгэлтэй шууд оролцогч нийт 34 байна. Үүнээс Андеррайтер 24, Дилер 24, Брокер 30, хөрөнгө оруулалтын сан 2 компани байна. Харин шууд оролцогч нарт бүртгэлтэй шууд бус оролцогч хувь хүн 3425, хуулийн этгээд 339 байна.

 3425
 339

№	ШУУД ОРОЛЦОГЧ	АНДЕРРАЙТЕР	ДИЛЕР	БРОКЕР	ХОС
1	Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК	✓	✓	✓	
2	Инвескор Капитал ҮЦК ХХК	✓	✓	✓	
3	Стандарт Инвестмент ҮЦК ХХК	✓	✓	✓	
4	Эм Ай Си Си ҮЦК ХХК	✓	✓	✓	
5	Ард Секюритиз ҮЦК ХХК	✓	✓	✓	
6	Гүүдсек ҮЦК ХХК	✓	✓	✓	
7	Голомт Капитал ҮЦК ХХК	✓	✓	✓	
8	Мирэ Эссэт Секьюритис Монгол ҮЦК ХХК	✓	✓	✓	
9	Би Ди Сек ҮЦК ХК	✓	✓	✓	
10	Нэйшнл Сэкюритис ҮЦК ХХК	✓	✓	✓	
11	Апекс Капитал ҮЦК ХХК	✓	✓	✓	
12	Райнос Инвестмент ҮЦК ХХК	✓	✓	✓	
13	Ти Ди Би Секьюритис ҮЦК ХХК	✓	✓	✓	
14	Таван Богд Капитал ҮЦК ХХК	✓	✓	✓	
15	Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК	✓	✓	✓	
16	Новел Инвестмент ҮЦК ХХК	✓	✓	✓	
17	Лайфтайм Инвестмент ҮЦК ХХК	✓	✓	✓	
18	Эс Жи Капитал ҮЦК ХХК	✓	✓	✓	
19	Стоклаб Секьюритиз ҮЦК ХХК	✓	✓	✓	
20	Аргай Бест ҮЦК ХХК		✓	✓	
21	Монсек ҮЦК ХХК		✓	✓	
22	Алтан хоромсог ҮЦК ХХК		✓	✓	
23	Ди Эйч Капитал ҮЦК ХХК		✓	✓	
24	Булган брокер ҮЦК ХХК		✓	✓	
25	Тэнгэр Капитал ҮЦК ХХК	✓		✓	
26	Мазаалай капитал партнерс ҮЦК ХХК	✓		✓	
27	Эс Жи Инвестмент Энд Секьюритис ҮЦК ХХК	✓		✓	
28	Нэтсэк ҮЦК ХХК			✓	
29	Үнэт Секьюритис ҮЦК ХХК			✓	
30	Бумбат Алтай ҮЦК ХХК			✓	
31	Тээвэр хөгжлийн банк ХХК	✓			
32	Голомт банк ХК	✓			
33	Би Жи Эм тогтмол орлогын багц хувийн ХОС ХХК				✓
34	Инвескор Ри Сайкл Хувийн ХОС ХХК				✓

IV-Р УЛИРЛЫН АРИЛЖААНЫ ТОЙМ:


Биржийн бус зах зээл 2024 оны IV улирлын байдлаар 45 үнэт цаас гаргагчийн, 48 өрийн хэрэгсэл бүртгэгдлээ. Үүнээс 857.5 тэрбум төгрөгийн өрийн хэрэгсэл бүртгэгдэж, 735.5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн байна. Харин ам.доллаароор 68.0 сая ам.доллар бүртгэгдэж 51.0 сая ам.доллар татан төвлөрүүлсэн байна

ТӨГРӨГӨӨР	2024Q4 /ТЭРБУМ ₮/	2024 /ТЭРБУМ ₮/
Бүртгэгдсэн дүн	857.5	1,781.9
Татан төвлөрүүлсэн дүн	735.5	1,670.2

АМ.ДОЛЛАРООР	2024Q4 /САЯ \$/	2024 /САЯ \$/
Бүртгэгдсэн дүн	68.0	91.8
Татан төвлөрүүлсэн дүн	51.0	71.9


АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ:

Тайлант хугацаанд төгрөгийн нийт арилжааны 69 хувь буюу 735.5 тэрбум төгрөг нь анхдагч зах зээлд, харин 31 хувь буюу 329.0 тэрбум төгрөг нь хоёрдогч зах зээлд хийгдсэн байна. Мөн ам.долларын нийт арилжааны 85 хувь буюу 51.0 сая ам.доллар нь анхдагч зах зээлд, 15 хувь буюу 9.2 сая ам.доллар нь хоёрдогч зах зээлд хийгдсэн байна.




БҮРТГЭГДСЭН БОНДЫН ДҮН: ЖИЛЭЭР

2024 оныг өмнөх 2023 онтой харьцуулахад бүртгэгдсэн дүн 56.7 хувь, татан төвлөрүүлсэн дүн 49.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



БҮРТГЭГДСЭН БОНДЫН ДҮН: УЛИРЛААР

2024 оны IV улиралд төгрөгийн бондын нийт дүнгийн 52 хувь, татан төвлөрүүлсэн дүнгийн 59 хувийг “Нийслэлийн ЗДТГ” болон “Монгол Улсын Хөгжлийн Банк” ХХК-аас гаргасан бонд эзэлж байна.



САЛБАРААР



Тайлант хугацаанд бүртгэгдсэн өрийн хэрэгслийг салбараар нь ангилбал Санхүү 47.5 хувь, Эрчим хүч 45 хувь, Барилга 3.7 хувь, Уул уурхай 2.3 хувь, Худалдаа үйлчилгээ 0.8 хувь Үйлдвэрлэл 0.6 хувийг эзэлсэн байна.



ӨГӨӨЖИЙН МУРУЙ: ЭРГЭН ТӨЛӨГДӨХ ХУГАЦААГААР

Идэвхтэй байгаа компанийн бонд В самбарын хувьд 24 сарын дараа төлөгдөх бондын өгөөж 6 сарын дараа төлөгдөх бондын өгөөжөөс 0.82 хувиар өндөр байна. Харин С самбарын хувьд 24 сарын дараа төлөгдөх бондын өгөөж 6 сарын дараа төлөгдөх бондын өгөөжөөс 0.73 хувиар бага байна.

*Хөрөнгө оруулагчтай харилцан тохиролцон хүүг багаар тооцсон компаниудын бондыг хасаж тооцсон болно



IV-Р УЛИРЛЫН АРИЛЖААНЫ ТОЙМ:

2024 ОНЫ IV УЛИРАЛД БҮРТГЭГДСЭН БОНД /ТӨГРӨГ/

№	БОНДЫН НЭР	САЛБАР	БҮРТГЭГДСЭН ӨДӨР	БҮРТГҮҮЛСЭН ДҮН
1	Net bond 17, 18	Санхүү	11/25/2024	₮3,500,000,000
2	Khan bond 4.1	Барилга	10/4/2024	₮3,000,000,000
3	Sono bond 5.1	Санхүү	10/7/2024	₮10,000,000,000
4	Bers bond 5.1	Санхүү	10/7/2024	₮11,000,000,000
5	Atmor bond 2	Барилга	10/14/2024	₮650,000,000
6	Simple bond 5.1	Санхүү	10/14/2024	₮25,000,000,000
7	Tsast bond 1	Барилга	10/16/2024	₮8,000,000,000
8	Automart bond 1	Худалдаа, үйлчилгээ	10/21/2024	₮400,000,000
9	Kingdom bond 1	Санхүү	10/21/2024	₮1,000,000,000
10	Dotno bond 1	Санхүү	10/21/2024	₮1,000,000,000
11	DBM bond 5	Санхүү	10/24/2024	₮142,458,000,000
12	Balanced credit bond 1	Санхүү	10/24/2024	₮1,250,000,000
13	Master bond 7.1	Барилга	11/1/2024	₮3,500,000,000
14	Khushhan bond 2	Үйлдвэрлэл	11/4/2024	₮1,000,000,000
15	Meta bond 1	Санхүү	11/4/2024	₮1,380,000,000
16	Trust bond 3.1	Санхүү	11/8/2024	₮2,500,000,000
17	Mandal bond 1.1	Уул уурхай	11/11/2024	₮20,000,000,000
18	TBFI bond 1	Санхүү	11/15/2024	₮60,000,000,000
19	CECI bond 1	Санхүү	11/15/2024	₮2,000,000,000
20	Eatopia bond 1	Худалдаа, үйлчилгээ	11/15/2024	₮1,500,000,000
21	Urmini bond 1	Үйлдвэрлэл	11/15/2024	₮500,000,000
22	Ashid bond 3	Санхүү	11/15/2024	₮2,000,000,000
23	Moneybox bond 2.1	Санхүү	11/15/2024	₮8,000,000,000
24	Advance bond 3	Санхүү	11/25/2024	₮980,000,000
25	WST bond 2	Санхүү	11/28/2024	₮4,350,000,000
26	State bank green bond 1	Санхүү	12/4/2024	₮10,000,000,000
27	Monplast bond 1	Худалдаа, үйлчилгээ	12/4/2024	₮1,300,000,000
28	Gerel finance bond 5	Санхүү	12/5/2024	₮2,000,000,000
29	Credit bond 3.1	Санхүү	12/5/2024	₮9,000,000,000
30	NC Mobile bond 1	Санхүү	12/9/2024	₮15,000,000,000
31	Sendly bond 1	Санхүү	12/13/2024	₮5,000,000,000
32	Bid bond 6	Санхүү	12/13/2024	₮2,000,000,000
33	NRT bond 1.1	Санхүү	12/13/2024	₮9,000,000,000
34	Ulaanbaatar hot EHHS bond 1	Эрчим хүч	12/17/2024	₮300,000,000,000
35	STIN bond 1	Санхүү	12/18/2024	₮500,000,000
36	GSB bond 6.1	Санхүү	12/18/2024	₮10,000,000,000
37	Lend bond 3	Санхүү	12/19/2024	₮6,000,000,000
38	Ulemj bond 1	Худалдаа, үйлчилгээ	12/19/2024	₮2,000,000,000
39	Kingdom bond 2	Санхүү	12/19/2024	₮1,000,000,000
40	Khushkhan bond 3	Үйлдвэрлэл	12/20/2024	₮3,820,000,000
41	IS bond 1	Худалдаа, үйлчилгээ	12/20/2024	₮2,000,000,000
42	CTM bond 4	Санхүү	12/20/2024	₮1,250,000,000
43	INVE bond	Санхүү	12/24/2024	₮50,000,000,000
44	Buuruljuut bond 2.1	Эрчим хүч	12/27/2024	₮85,518,750,000
45	Eco credit bond 1	Санхүү	12/27/2024	₮2,100,000,000
46	Shijir bond 2	Санхүү	12/27/2024	₮8,000,000,000
47	Talst tower bond 1.1	Барилга	12/30/2024	₮17,000,000,000


2024 ОНЫ IV УЛИРАЛД БҮРТГЭГДСЭН БОНД /АМ.ДОЛЛАР/

№	БОНДЫН НЭР	САЛБАР	БҮРТГЭГДСЭН ӨДӨР	БҮРТГҮҮЛСЭН ДҮН
1	Net bond 17, 18	Санхүү	11/25/2024	₮3,500,000,000
2	Khan bond 4.1	Барилга	10/4/2024	₮3,000,000,000
3	Sono bond 5.1	Санхүү	10/7/2024	₮10,000,000,000

IV-Р УЛИРЛЫН АРИЛЖААНЫ ТОЙМ:


БОНДЫН ХУГАЦАА:

Тайлант хугацаанд бүртгэгдсэн нийт бондын 68 хувийг 12 сарын хугацаатай бонд, 13 хувийг 18 сарын хугацаатай бонд, 10 хувийг 24 сарын хугацаатай бонд, 9 хувийг 48 сар ба түүнээс дээш сарын хугацаатай бонд тус тус бүрдүүлээ.



ЭРГЭН ТӨЛӨЛТ:

Биржийн бус зах зээл 2021 оны 9 сард анхны өрийн хэрэгслээ бүртгэж үйл ажиллагаагаа эхэлснээс хойш нийт 1,060.5 тэрбум төгрөгийн өрийн хэрэгслийн хугацаа дуусаж, эргэн төлөлт хийгдлээ. Харин тайлант хугацаанд 357.7 тэрбум төгрөг болон 12.0 сая ам.долларын өрийн хэрэгслийн эргэн төлөлт амжилттай хийгдсэн байна.



БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ШУУД ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗӨВЛӨГӨӨ:

1. Үнэт цаас гаргагчийн хүү, үндсэн төлбөр эргэн төлөлтийн тайлан, тогтмол болон тухай бүр мэдээлэх мэдээллийг тухайн хугацаа бүрт, тайланг зөв бөглөж WWW.OTC.MN-д оруулах;
2. ШБО-ын тоон мэдээллийн тайлан, андеррайтерын улирлын тайланг тухайн заасан хугацаанд багтаан ирүүлэх;
3. Андеррайтерын улирлын тайланг тухайн ҮЦК-ийн гүйцэтгэх захирлын гарын үсэг зурснаар баталгаажуулан ирүүлдэг байх;
4. Төслийн танилцуулгад техник шинжтэй алдаанууд гаргахгүй байх;
5. Гаргаж буй өрийн хэрэгсэл нь их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдож байгаа бол эрх бүхий этгээдийн шийдвэрт заавал дурдах;
6. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч 1 бол хувьцаа эзэмшигчийн шийдвэр, 2 ба түүнээс дээш бол хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гаргана.
7. Өрийн хэрэгсэлд компани бол баталгаа гаргана, хувь хүн бол батлан даалт гаргана.
8. Өрийн хэрэгсэл гаргахтай холбоотойгоор хийгдэж байгаа албан бичиг, баримт бичгийн үг, үсгийн алдааг сайтар шалгаж байх.